



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/172

Булган сум

Аймаг дахь чадавх бэхжүүлэх багийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан "Тогтвортой амьжиргаа-3" төслийн санхүүжилтийн хэлэлцээр, Сангийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Тогтвортой амьжиргаа-3" төслийн аймаг дахь чадавх бэхжүүлэх баг (цаашид АЧББ гэх)-ийг дараах бүрэлдэхүүнтэй өөрчлөн байгуулсугай.

Багийн ахлагч:	Д.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	Б.Оюунболд (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга, өөртэй нь зөвшилцсөнөөр) Ч.Ариун (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Иргэдийн оролцоо, сум хариуцсан мэргэжилтэн, өөртэй нь зөвшилцсөнөөр) Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн) Б.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) Э.Эрболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажилтан) Б.Баярцэнгэл (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Мөнхбаяр (Орон нутгийн төслийн ажилтан) Б.Бумцэнд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийг дэмжих Засгийн газрын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн түвшинд ажиллах чадавхыг хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт хийн, тайлагнахыг багийн ахлагч (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/296 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ